



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

 **IOM**
UN MIGRATION

ГАДААД УЛСАД АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Судалгааны үр дүнгийн тайлан

Улаанбаатар хот
2023

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	2
СУДАЛГААНЫ БАГ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	7
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	8
ХУРААНГУЙ.....	9
1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	10
1.1 Танилцуулга.....	10
1.2 Судалгааны аргачлал	10
1.3 Мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт	13
1.4 Хариултын түвшин	14
2 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ШИНЖ БАЙДАЛ	15
2.1 Хүн ам зүйн мэдээлэл	15
3 ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН	19
4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ОРЛОГО.....	27
4.1 Хөдөлмөр эрхлэлт	27
4.2 Орлого, түүний эх үүсвэр	29
4.3 Эрүүл мэндийн болон нийгмийн даатгал.....	33
5 ГУЙВУУЛГА, ИЛГЭЭМЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	36
5.1 Мөнгөн гуйвуулга болон мөнгө бус илгээмж.....	36
5.2 Хөрөнгө оруулах боломж.....	40
6 ИРЭЭДҮЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	42
ДҮГНЭЛТ	50
ХАВСРАЛТ	51
Хавсралт 1. Хүснэгтүүд	51
Хавсралт 2. Гадаад оршин суугаа иргэдийн нөхцөл байдлын судалгааны асуулга.....	78

ӨМНӨХ ҮГ


Үндэсний Статистикийн Хорооноос Монгол Улсын Хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд гарч буй өөрчлөлтийг Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагатай хамтран судалж ирсэн. Энэ удаагийн судалгааг Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын хүсэлтээр хоёр байгууллагын хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд зохион байгууллаа.

Судалгаа нь гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэдэд тулгамдаж буй асуудал, эх орондоо буцан ирэх төлөвлөгөө болон тэдгээрийн өрхөд үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох, үүнд чиглэсэн дунд, урт хугацааны бодлого, хөтөлбөр боловсруулах, судалгаа шинжилгээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах зорилготой юм.

Судалгааны мэдээлэл цуглуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагын суурин төлөөлөгчийн газар, Гадаад Харилцааны Яамны Консулын газар, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газрын хамт олонд талархал илэрхийлье.

Энэхүү судалгааны тайлан нь гадаад улсад ажиллаж амьдарч байгаа иргэдийн нөхцөл байдлын дүр зургийг харуулахаас гадна гүнзгийрүүлсэн судалгаа, шинжилгээний ажил боловсруулахад мэдээллийн гол эх үүсвэр болно гэдэгт эргэлзэхгүй байна. Түүнчлэн гадаад улсад оршин суугаа иргэдэд чиглэсэн судалгаа, бүртгэлийн ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд томоохон туршлага болно гэдэгт итгэлтэй байна.

ДАРГА



Б.БАТДАВАА

СУДАЛГААНЫ БАГ

ТАЙЛАНГ ХЯНАСАН

Б.БАТДАВАА

Санхүүч, Банк, санхүүгийн шинжлэх ухааны магистр
ҮСХ-ны дарга

А.СОЛОНГО

Хүн ам зүйч, Доктор, Профессор
МУИС, Шинжлэх Ухааны Сургууль-Нийгмийн ухааны сургууль, Антропологи,
археологийн тэнхимийн багш

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН

Ш.АРИУНБОЛД

Эдийн засагч-Статистикч, Хэрэглээний статистикийн магистр
ҮСХ-ны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга

Б.УРАНБИЛЭГ

Эдийн засагч-Хүн ам зүйч, Бизнесийн удирдлагын магистр
ҮСХ-ны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Хүн ам, орон сууцны
тооллогын хэлтсийн статистикч

М.БАЯРЖАРГАЛ

Эдийн засагч, Хүн ам зүйн магистр
ҮСХ-ны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Хүн ам, орон сууцны
тооллогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор гадаадад тоологдсон иргэдийн тоо болон судалгаанд хамруулахаар төлөвлөсөн иргэдийн тоо, улсаар	12
Хүснэгт 1.2. Судалгааны асуулгын хураангуй тайлбар, бүлэг бүрээр	13
Хүснэгт 1.3. Судалгаанд оролцогчдын нийт тоо, тайлан боловсруулахад боломжтой болон хасагдсан шалтгаанаар.....	15
Хүснэгт 2.1. Судалгаанд оролцогчдын тоо, хүйсийн харьцаа, насны бүлэг, хүйсээр, хувь	16
Хүснэгт 2.2. Судалгаанд оролцогчдын тоо, боловсролын түвшин, оршин суугаа улс, хувиар	17
Хүснэгт 2.3. Судалгаанд оролцогчдын тоо, үндсэн мэргэжил, хүйсээр, ЯАМАТ-оор, хувь	18
Хүснэгт 2.4. Судалгаанд оролцогчдын тоо, гэрлэлтийн байдал, насны бүлгээр, хувь ..	18
Хүснэгт 2.5. Судалгаанд оролцогчдын тоо, гэрлэлтийн байдал, улсаар, хувь	19
Хүснэгт 3.1. Судалгаанд оролцогчдын тоо, гадаадад ирсэн үндсэн зорилго, насны бүлэг, хүйсээр, хувь	21
Хүснэгт 3.2. Судалгаанд оролцогчдын тоо, гадаадад ирсэн үндсэн зорилго, улс, хувь ..	22
Хүснэгт 3.3. Судалгаанд оролцогчдын тоо, оршин суугаа зөвшөөрлийн хэлбэр, насны бүлэг, хүйсээр, хувь.....	23
Хүснэгт 3.4. Судалгаанд оролцогчдын тоо, оршин суугаа зөвшөөрлийн хэлбэр, улсаар, хувь	23
Хүснэгт 3.5. Судалгаанд оролцогчдын тоо, улсаар, амьдран суугаа сууцны төрлөөр, хувь	24
Хүснэгт 3.6. Судалгаанд оролцогчдын тоо, бэрхшээл тулгарсан эсэх, байр сууриа олоход зарцуулсан хугацаагаар, хувь.....	24
Хүснэгт 3.7. Судалгаанд оролцогчдын тоо, гадаадад амьдарснаар гарсан өөрчлөлт, дүн, хувиар	26
Хүснэгт 4.1. Судалгаанд оролцогчдын тоо, хөдөлмөр эрхэлж байгаа эсэх, улс, ажлын тооны ангиллаар, хувь	28
Хүснэгт 4.2. Хөдөлмөр эрхэлж байгаа судалгаанд оролцогчдын тоо, эрхэлж байгаа ажлын чиглэл, хүйсээр, хувь.....	29
Хүснэгт 4.3. Хөдөлмөр эрхэлж байгаа судалгаанд оролцогчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн шинж байдлаар, хувь	29
Хүснэгт 4.4. Судалгаанд оролцогчдын сарын дундаж орлого, хөдөлмөр эрхэлдэг эсэх, улсаар, хувь, мянган төгрөгөөр	32
Хүснэгт 4.5 Судалгаанд оролцогчдын сарын дундаж орлого, улсуудаар, хэрэглээнд хангалттай эсэх, мянган төгрөгөөр.....	32
Хүснэгт 4.6. Судалгаанд оролцогчдын тоо, даатгалд хамрагдсан байдал, улсаар, хувь.....	35
Хүснэгт 5.1. Судалгаанд оролцогчдын тоо, Монгол улс гуйвуулга хийсэн эсэх, нөхцөл байдал.....	37
Хүснэгт 5.2. Гуйвуулга, илгээмж явуулсан иргэдийн мөнгөн гуйвуулга болон мөнгөн бус илгээмжийн жилийн дундаж хэмжээ, хүйсээр, насны бүлгээр, мянган төгрөгөөр.....	39
Хүснэгт 5.3 Гуйвуулга, илгээмж явуулсан иргэдийн мөнгөн гуйвуулга болон мөнгөн бус илгээмжийн жилийн дундаж хэмжээ, улсаар.....	38
Хүснэгт 5.4 Гуйвуулга, илгээмж явуулсан иргэдийн жилийн дундаж гуйвуулга, илгээмжийн сарын дундаж орлогод эзлэх хувь, улсаар.....	39
Хүснэгт 6.1. Судалгаанд оролцогчдын тоо, иргэдийн ирээдүйн төлөвлөгөө, хувь.....	43
Хүснэгт 6.2. Судалгаанд оролцогчдын тоо, Монгол улс руу буцах төлөвлөгөөтэй эсэх, улсаар, хугацаагаар.....	44
Хүснэгт 6.3. Судалгаанд оролцогчдын тоо, гадаадад амьдарч байгаа иргэдийг дэмжих тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, хувь	49

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Судалгааны мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт	15
Зураг 2.1. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа, зарим улсуудаар, хувь.....	16
Зураг 2.2. Судалгаанд оролцогчдын тоо, боловсролын түвшин, хувиар.....	16
Зураг 2.3. Судалгаанд оролцогчдын тоо, хаана боловсрол эзэмшсэнээр, хувь	17
Зураг 2.4. Судалгаанд оролцогчдын тоо, хамт амьдарч байгаа гишүүдийн тооны бүлгээр, хувиар.....	19
Зураг 2.5. Судалгаанд оролцогчдын тоо, хамт амьдардаг өрхийн гишүүний хамаарлаар, хувиар (давхардсан тоогоор).....	19
Зураг 3.1. Судалгаанд оролцогчдын тоо, гадаад улсад амьдарсан хугацаагаар, хувь	20
Зураг 3.2. Судалгаанд оролцогчдын тоо, төрсөн аймгаар, хувь	20
Зураг 3.3. Судалгаанд оролцогчдын тоо, Монгол Улсад хамгийн сүүлд амьдарч байсан газар, хувиар	21
Зураг 3.4. Судалгаанд оролцогчдын тоо, оршин суух зөвшөөрөлтэй эсэх, улсаар, хувь	22
Зураг 3.5. Бэрхшээл тулгарсан судалгаанд оролцогчдын тоо, бэрхшээлийн төрөл, хүйсээр, хувь, давхардсан тоогоор	25
Зураг 3.6. Судалгаанд оролцогчдын тоо, төрөөс үйлчилгээ авахад бэрхшээл тулгарсан эсэх, хувиар	25
Зураг 3.7. Төрийн үйлчилгээ авахад хүндрэлтэй гэж хариулсан судалгаанд оролцогчдын тоо, төрийн үйлчилгээ авахад тулгарч буй асуудлууд, хувиар	26
Зураг 3.8. Судалгаанд оролцогчдын тоо, гадагш явах зардлаа шийдвэрлэсэн байдал, хувиар	26
Зураг 3.9. Судалгаанд оролцогчдын тоо, тэдгээрийн амьдрал гарсан эерэг өөрчлөлт, хувиар, давхардсан тоогоор	27
Зураг 3.10. Судалгаанд оролцогчдын тоо, тэдгээрийн амьдрал гарсан сөрөг өөрчлөлт, хувиар, давхардсан тоогоор	27
Зураг 4.1. Хөдөлмөр эрхэлж байгаа судалгаанд оролцогчид, байнга хөдөлмөр эрхлэгч, хэвийн нөхцөлд хөдөлмөр эрхлэгчдийн хувийн жин	30
Зураг 4.2. Судалгаанд оролцогчдын сарын дундаж орлого, хүйс, мянган төгрөгөөр ...	30
Зураг 4.3. Судалгаанд оролцогчдын тоо, орлогын эх үүсвэрээр, хувь, давхардсан тоогоор.....	31
Зураг 4.4. Судалгаанд оролцогчдын сарын дундаж орлого, насны бүлэг, боловсролын түвшин, байдлаар, мянган төгрөгөөр	31
Зураг 4.5. Судалгаанд оролцогчдын сарын дундаж орлого, ажлын байдал, хэрэглээнд хангалттай эсэхээр, мянган төгрөгөөр	33
Зураг 4.6. Судалгаанд оролцогчдын тоо, даатгалд хамрагдсан байдал, хувь.....	34
Зураг 5.1. Судалгаанд оролцогчдын тоо, гуйвуулга, илгээмж илгээсэн зорилгоор, хувь, давхардсан тоогоор	37
Зураг 5.2. Судалгаанд оролцогчдын тоо, гуйвуулга, илгээмжийг хүлээн авагчийн төрлөөр, хувь, давхардсан тоогоор.....	38
Зураг 5.3. Судалгаанд оролцогчдын тоо, явуулсан илгээмжийн төрлөөр, хувь, давхардсан тоогоор	38
Зураг 5.4. Судалгаанд оролцогчдын тоо, гуйвуулга, илгээмжийг явуулахад бэрхшээл тулгардаг эсэх, хувь	38
Зураг 5.5. Гуйвуулга, илгээмж явуулсан иргэдийн тоо, жилийн дундаж гуйвуулга, илгээмжийн сарын дундаж орлогод эзлэх хувиар	40
Зураг 5.6. Судалгаанд оролцогчдын тоо, хөрөнгө оруулах боломжийн талаар мэддэг эсэх, хувиар	41

Зураг 5.7. Хөрөнгө оруулах боломжийн талаар мэдлэгтэй судалгаанд оролцогчдын тоо, хөрөнгө оруулах боломжийн талаар мэдээлэл олж авсан сувгаар, хувь, давхардсан тоогоор..... 41

Зураг 5.8. Хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа судалгаанд оролцогчдын тоо, төлөвлөж байгаа хөрөнгө оруулалтын хэлбэр, хувиар, давхардсан тоогоор 41

Зураг 5.9. Хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа судалгаанд оролцогчдын тоо, хөрөнгө оруулалт хийхээр сонирхож байгаа салбар, хувиар, давхардсан тоогоор 42

Зураг 6.1. Буцах төлөвлөгөөтэй байгаа судалгаанд оролцогчдын тоо, буцаж ирээд амьдрах байршил, хувиар 43

Зураг 6.2. Буцах төлөвлөгөөтэй байгаа иргэдийн тоо, буцах шийдвэр гаргахад нөлөөлсөн гол шалтгаан, хувиар, давхардсан тоогоор..... 45

Зураг 6.3. Буцах төлөвлөгөөтэй байгаа иргэдийн тоо, Монгол улсад ирээд хийхээр төлөвлөж байгаа хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, хувь, давхардсан тоогоор 45

Зураг 6.4. Цалин хөлстэй хөдөлмөр болон бизнес эрхлэх иргэдийн тоо, Монгол улсад ирээд ажиллахаар төлөвлөсөн салбар, хувь 46

Зураг 6.5. Буцах төлөвлөгөөтэй байгаа иргэдийн тоо, Монгол Улсад амьдрахад хамгийн түрүүнд шийдвэрлэх асуудлын төрөл, хувиар, давхардсан тоогоор 47

Зураг 6.6. Судалгаанд оролцогчдын тоо, Монгол Улсад нэвтрүүлж болох шинэлэг санаа, хувиар, давхардсан тоогоор 47

Зураг 6.7. Судалгаанд оролцогчдын тоо, Монгол Улсын иргэд гадаадад амьдарснаар Монгол Улсад оруулж буй хувь нэмэр, хувиар, давхардсан тоогоор 48

Зураг 6.8. Судалгаанд оролцогчдын тоо, Монгол улсын иргэд гадаадад амьдарснаар Монгол Улсад үзүүлж буй сөрөг нөлөө, хувиар, давхардсан тоогоор 48

Зураг 6.9. Буцах төлөвлөгөөгүй байгаа иргэдийн тоо, шийдвэр гаргалтад нөлөөлсөн шалтгаанаар, хувиар, давхардсан тоогоор..... 49

Зураг 6.10. Буцах төлөвлөгөөгүй байгаа иргэдийн тоо, боловсролын түвшин, насны бүлгээр, хувиар..... 50

Зураг 6.11. Монгол Улс руу буцах төлөвлөөгүй иргэдийн гэрлэлт, одоогийн амьдарч байгаа улсад гэр бүлийн хамт амьдардаг эсэх, хувиар 50

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	- Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	- Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	- Бүгд Найрамдах Хятад Улс
ГХЯ	- Гадаад Харилцааны Яам
ДТГ	- Дипломат төлөөлөгчийн газар
НҮБ	- Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУШХБ	- Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага
ОХУ	- Оросын Холбооны Улс
СЯ	- Сангийн Яам
ТӨШГ	- Тооллого, өгөгдлийн шинжилгээний газар
ҮАМАТ	- Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт
ҮСХ	- Үндэсний Статистикийн Хороо
ХАОСТХ	- Хүн ам, орон сууцны тооллогын хэлтэс
ХБНГУ	- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНХЯ	- Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ЭЗХЯ	- Эдийн Засгийн Хөгжлийн Яам

ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

Байнга оршин суугаа газар: 183 хоногоос дээш хугацаагаар оршин сууж байгаа болон 183 хоногоос доош хугацаагаар сууж байгаа ч цаашид 183 хоногоос дээш хугацаагаар оршин суух нь тодорхой болсон газар нутгийг хэлнэ.

Байнга оршин суугч: Монгол Улсад 183 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа болон 183 хоногоос доош хугацаагаар сууж байгаа ч цаашид 183 хоногоос дээш хугацаагаар оршин суух нь тодорхой хүнийг хамруулна.

Гадаад шилжих хөдөлгөөн: Монгол Улсад өөр улс орноос шилжин ирэгчид болон Монгол Улсаас өөр улсад шилжин явагчдын хөдөлгөөний урсгал байна.

Гадаад шилжих хөдөлгөөнд оролцогч: Байнга оршин суудаг улс орноос 183 хоногоос дээш хугацаагаар өөр улсад шилжигчид байна. Гадаад шилжих хөдөлгөөнд оролцогчдод дараах хүмүүсийг хамруулна. Үүнд:

Монгол Улсын иргэний хувьд:

1. Гадаадад 183 хоногоос дээш хугацаагаар шилжин явж буй хүн;
2. Гадаадад 183 хоногоос дээш хугацаагаар оршин сууж байгаад эх орондоо 183 хоногоос дээш хугацаагаар шилжин ирж буй хүн;

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэж заасан нь иргэд шилжих хөдөлгөөнд сайн дураараа чөлөөтэй оролцох эрх зүйн боломжийг бүрдүүлдэг.

Үндэсний ажил мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолтыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар тушаалаар баталсан.

Мэргэжилтэн: Мэргэжилтэн гэдэгт биет бодис /физик/, гео судлалын мэргэжилтэн, математикч, актаурч, статистикч, амьд байгалийн ухааны мэргэжилтэн, инженер мэргэжилтэн (цахим технологиос бусад), цахилгаан, цахим технологийн инженер, архитектор, төлөвлөгч, газарзүйч, байрзүйч, дизайнч, хүний их эмч, сувилахуй, эх барихуйн мэргэжилтэн, уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн, яаралтай тусламжийн эмч, малын эмч, эрүүл мэндийн бусад мэргэжилтэн, их, дээд сургуулийн дээд боловсролын багш, техник мэргэжлийн боловсролын багш, дунд боловсролын багш, анхан шатны болон сургуулийн өмнөх боловсролын багш, сурган хүмүүжүүлэгч, бусад багшлах мэргэжилтэн, санхүүгийн мэргэжилтэн, захиргааны мэргэжилтэн, борлуулалт, маркетинг, олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн, программ хангамж, хэрэглээний программ зохиогч, шинжээч, өгөгдлийн сан, сүлжээний мэргэжилтэн, эрх зүйн мэргэжилтэн, номын санч, архивч, музейн хариуцагч, нийгэм шашны мэргэжилтэн, зохиолч, сэтгүүлч, хэл шинжлэл, уран бүтээлч, жүжигчин багтана.

Менежер: Менежер гэдэгт хууль тогтоогч, удирдах албан тушаалтан, захирал, гүйцэтгэх захирал, бизнес, үйлчилгээ, захиргааны менежер, хөдөө аж ахуй, ой, загас ан агнуурын үйлдвэрлэлийн менежер, үйлдвэр, уурхай, барилга угсралт, хангамжийн түгээлтийн менежер, мэдээлэл, холбооны технологи үйлчилгээний менежер, мэргэшсэн үйлчилгээний менежер, зочид буудал, рестораны менежер, жижиглэн болон бөөний худалдааны менежер, холбогдох бусад үйлчилгээний менежер багтана.

ХУРААНГУЙ

Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдал судалгаа нь гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдлыг тодорхойлж, тэдгээрийн мөнгөн болон мөнгөн бус гуйвуулгын өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөөг судлахад чиглэгдсэн. Түүнчлэн буцах шилжилт хөдөлгөөнийг дэмжих бодлого боловсруулахад шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэх зорилготой.

Энэхүү судалгаанд БНСУ (Бүгд Найрамдах Солонгос Улс), АНУ (Америкийн Нэгдсэн Улс), Япон, Казахстан, Чех, Австрали, БНХАУ (Бүгд Найрамдах Хятад Улс), ХБНГУ (Холбооны Бүгд Найрамдах Герман Улс), Швед, Франц, ОХУ (Оросын Холбооны Улс), Турк, Австри, Швейцар, Их Британи болон бусад улсуудад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа 1865 иргэний мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Эдгээр иргэдийн дундаж нас 35.3 (18-90 нас), дунджаар 6.6 жил (6 сар-41 жил) гадаадад амьдарсан ба 62.5 хувь нь эмэгтэй, 37.5 хувь нь эрэгтэй, 70 гаруй хувь нь дипломын болон түүнээс дээш боловсролтой, 34.2 хувь нь ганцаараа амьдардаг, 39.5 хувь нь өрхийн 1-3 гишүүнтэйгээ хамт амьдардаг байна.

Мөн судалгаанд хамрагдсан иргэдийн 85.0 хувь нь оршин суух зөвшөөрөлтэй байгаа ба дийлэнх нь суралцах, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй, 1347 (72.2 хувь) нь ажил эрхэлж байгаа. Ажил хийж байгаа 90.3 хувь нь хэвийн нөхцөлд, 54.6 хувь нь байнгын буюу тогтмол хугацаатай гэрээтэй, 69.7 хувь нь 7 хоногт 35-аас дээш цагаар ажилладаг байна. Гадаад улсад оршин суугаа эдгээр иргэдийн 73.9 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд Монгол Улсад гуйвуулга, илгээмж явуулсан байна. Тухайлбал, нэг иргэн жилд дунджаар 19.9 сая төгрөгийг ихэвчлэн өрхийн өдөр тутмын хэрэгцээнд зориулан илгээжээ.

Судалгаанд хамрагдагсдын 61.0 хувь нь Монгол Улсад буцаж ирэх төлөвлөгөөтэй бөгөөд үүний тал хувь нь 5 жил дотор буцахаар төлөвлөж байгаа бол 39.0 хувь нь нутаг буцах төлөвлөөгүй, 23.1 хувь нь оршин суугаа улсынхаа иргэн болох бодолтой байна. Харин буцаж ирэх төлөвлөгөөтэй иргэдийн хувьд эрүүл тав тухтай орчныг бүрдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, эдийн засгийг тогтвортой байлгах зэрэг амьдрах орчин, нөхцөл, нийгмийн үйлчилгээг сайжруулах асуудлыг шийдвэрлэхийг илүүтэй хүссэн байна.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Танилцуулга

Монгол Улс нь хилийн чанадад суралцаж, ажиллаж амьдарч байгаа иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эх орондоо эргэн ирэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр шат дараатай бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг эх орондоо эргэн ирж ажиллах, хилийн чанадаас улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах таатай нөхцөлийг бүрдүүлэх талаар тусгасан.

Манай улсын иргэд сурч боловсрох, хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх, бизнес эрхлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, гэр бүл болох зэрэг олон шалтгаанаар гадаадын улс орнуудад зорчих хөдөлгөөн улам бүр нэмэгдсэн.

ҮСХ-ны зохион байгуулж явуулдаг Хүн ам, орон сууцны тооллого нь гадаад шилжих хөдөлгөөний статистикийн үндсэн эх үүсвэр болох бөгөөд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж, ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн тоо мэдээллийг тодорхойлох асуудлыг тооллогын тухай хуульд тусгасан. Тооллого нь хөгжлийн үр дүнтэй төлөвлөлт, бодитой шийдвэр гаргахад үндсэн мэдээллийн эх үүсвэр болдог ч гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, тэдгээрийн өрхийн аж, амьдралд үзүүлэх үр нөлөөг судлахад хангалттай бус байна.

Иймд Үндэсний статистикийн хороо нь НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)-тай хамтран “Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдал” судалгааг зохион байгууллаа.

1.2 Судалгааны аргачлал

Судалгаа нь гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдлыг тодорхойлж, тэдгээрийн мөнгөн болон мөнгөн бус гуйвуулгын өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөөг судлахад чиглэгдсэн. Түүнчлэн буцах шилжилт хөдөлгөөнийг дэмжих бодлого боловсруулахад шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэх нь судалгааны үндсэн зорилт болно.

Түүврийн арга зүй

Судалгааны мэдээлэл цуглуулалтын үндсэн нэгж нь гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол Улсын харьяат насанд хүрсэн (18, түүнээс дээш насны) иргэн байна. Хамрах хүрээг улс болгоноор нарийвчлан тогтоож, иргэдийн жагсаалтыг бэлтгэхэд хүндрэлтэй тул энэхүү судалгаанд магадлалт бус түүврийн аргыг ашигласан. Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор Монгол Улсын харьяат 122.3 мянган иргэн гадаадад оршин сууж, ажиллаж, амьдарч байна. Энэхүү тоонд үндэслэн Монгол улсын иргэдийн дийлэнх нь оршин суугаа 15 орныг сонгон, түүврийн хэмжээг 2500 байхаар тооцсон.

Түүврийн хуваарилалтыг хийхдээ эхлээд улсуудыг хамгийн их иргэн тоологдсон дарааллаар эрэмбэлж, тэдгээрт харгалзах түүврийн хэмжээг ихээс бага байхаар зорилттойгоор хуваарилсан. Эдгээр 15 улсад нийт гадаад улсад байгаа иргэдийн 92.4 хувь нь тооллогын үед амьдарч байжээ.

Хүснэгт 1.1. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор гадаадад тоологдсон иргэдийн тоо болон судалгаанд хамруулахаар төлөвлөсөн иргэдийн тоо, улсаар

№	Тив	Улс	Гадаадад тоологдсон иргэдийн тоо (ХАОСТ-2020)	Төлөвлөсөн түүврийн хэмжээ
1	Ази	БНСУ	39 982	440
2	АНУ	АНУ	19 970	300
3	Ази	Япон	8 772	200
4	Ази	Казахстан	7 218	190
5	Европ	Чех	5 997	170
6	Австрали	Австрали	5 538	160
7	Ази	БНХАУ	5 146	160
8	Европ	ХБНГУ	3 972	140
9	Европ	Швед	3 951	140
10	Европ	Франц	3 102	120
11	Европ	ОХУ	2 814	120
12	Ази	Турк	2 716	110
13	Европ	Австри	1 676	90
14	Европ	Швейцар	1 469	80
15	Европ	Их Британи	1 466	80
Нийт			113 789	2500

Судалгааны асуулга, үзүүлэлт

Судалгааны асуулгыг Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын шилжих хөдөлгөөний шинжээчдийн бүлгээс боловсруулсан олон улсын шилжих хөдөлгөөний стандарт асуулгын зөвлөмж, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ны захиалгаар Хүний хөгжил судалгаа, сургалтын төвийн 2015 онд явуулсан судалгааны асуулга, Монгол Улсад баримталж байгаа бодлого, хөтөлбөрийн зорилго, зорилт зэрэгт үндэслэн боловсруулсан (Хавсралт 1).

Судалгааны асуулга нь дараах 5 үндсэн бүлгийн 75 асуултаас бүрдэнэ. Үүнд:

- Ерөнхий асуулга
- Шилжилт хөдөлгөөн
- Хөдөлмөр эрхлэлт
- Гуйвуулга, илгээмж, хөрөнгө оруулалт
- Ирээдүйн төлөвлөгөө багтана.

Хүснэгт 1.2. Судалгааны асуулгын хураангуй тайлбар, бүлэг бүрээр

№	Бүлэг, асуултын дугаар	Бүлгийн тайлбар	Хүлээгдэж буй үр дүн
1	Ерөнхий асуулга G1-G13	Тухайн судалгаанд оролцогчийн одоо амьдарч байгаа улс, нас, хүйс, боловсрол, мэргэжил, гэр бүлийн байдал, сууцны төрөл зэрэг ерөнхий асуултууд багтсан.	Энэ бүлгээс судалгаанд хамрагдагчдын нийгэм, хүн ам зүйн ерөнхий дүр зургийг харуулах зорилт тавьсан.
2	Шилжилт хөдөлгөөн M1-M17	Гадаад улсад оршин сууж буй хугацааг хэдэн онд Монгол Улсаас гарсан, одоо байгаа улсдаа хэзээнээс амьдарч байгаа зэрэг асуултаар, явсан зорилго, хууль ёсоор амьдардаг эсэх, гадаад улсад очсоны дараа тохиолдсон бэрхшээлүүд, амьдралд нь гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүд, гадаад улс руу явах зардлаа хэрхэн шийдвэрлэсэн зэрэг асуултууд багтсан.	Гадаад улсад оршин суух шалтгаан, хугацаа зэрэг шилжих хөдөлгөөнтэй холбоотой гол мэдээллийг харуулах зорилт тавьсан.
3	Хөдөлмөр эрхлэлт L1-L17	Хөдөлмөр эрхлэлтийн байдал, сарын дундаж орлого, даатгалд хамрагддаг эсэх, гадаад руу явахаас өмнө Монгол Улс дах хөдөлмөр эрхлэлтийн байдал зэрэг асуултууд багтсан.	Хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг харуулах зорилт тавьсан.
4	Гуйвуулга, илгээмж, хөрөнгө оруулалт S1-S15	Монгол Улсад байгаа гэр бүлийнхэнтэйгээ харилцаа, холбоо тогтоож байгаа эсэх; мөнгөн болон мөнгөн бус гуйвуулга явуулдаг эсэх, гуйвуулгын хэмжээ, илгээх болсон зорилго, хүлээн авагч; холбоотой хүндрэл бэрхшээл, Монгол Улсад хөрөнгө оруулах боломжийн талаарх асуултууд багтсан.	Гадаад улсад оршин суугаа иргэд нь Монгол Улсдаа оруулж буй мөнгөн болон мөнгөн бус гуйвуулга, хөрөнгө оруулалт хийх сонирхол зэрэг эдийн засгийн үр нөлөөг харуулах зорилт тавьсан.
5	Ирээдүйн төлөвлөгөө F1-F13	Төрөөс иргэдийг буцаж ирэхэд шийдвэрлэх асуудал, гадаадад удаан хугацаагаар оршин суух эерэг, сөрөг тал, мөн оршин суугаа улсаас Монгол Улсад эргэн очихдоо аль аймаг/хотод амьдрах гэсэн асуултууд багтсан.	Төрөөс иргэдийг буцаж ирэхэд нэн түрүүнд шийдвэрлэвэл зохих асуудлыг тодорхойлж, эрэмбэлэх, улмаар иргэдийн эх нутагтаа буцах төлөвлөгөөг харуулах зорилт тавьсан.

Мэдээлэл цуглуулалтын арга

Мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэхдээ цахим хуудсанд суурилсан асуулгын программыг боловсруулж ашигласан. Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэд сайн дурын үндсэн дээр www.moncitizen.gov.mn цахим холбоосоор нэвтэрч судалгааны асуулгыг бөглөсөн.

Судалгааны тухай мэдээлэл, асуулгын холбоос (www.moncitizen.gov.mn)-ыг ГХЯ, Дипломат төлөөлөгчийн газар, тэдэнтэй хамтран ажилладаг гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын цахим хуудас, нийгмийн сүлжээний сувгийг ашиглан түгээж, иргэдийг идэвхтэй оролцуулах сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.

Түүнчлэн цахим сүлжээ ашиглах боломжгүй тохиолдолд тухайн оронд үйл ажиллагаа явуулж буй Дипломат төлөөлөгчийн газар иргэдээс нүүр тулсан ярилцлагын аргаар, цаасаар мэдээллийг цуглуулж, ҮСХ-нд цахим шуудангаар дамжуулсан.

Мэдээлэл цуглуулалтыг 2023 оны 5-р сарын 25-наас 6-р сарын 14-ний өдрийн хооронд нийт 21 хоног хугацаанд гүйцэтгэсэн. Судалгааны мэдээлэл цуглуулалтад ГХЯ-ны Консулын газар болон 15 орны дипломат төлөөлөгчийн газрын 50 ажилтан оролцсон болно.

Мэдээлэл боловсруулалт

Судалгааны цаасаар нөхсөн асуулгыг шивэх, кодлох, шалгах, засварлах болон үр дүнгийн хүснэгтийг боловсруулахад статистик судалгааны SPSS программыг ашигласан. Мэдээллийн үзүүлэлт хоорондын уялдааны шалгалтыг гурван үе шаттайгаар хийсэн. Үүнд:

1. Өгөгдлийг программ хангамжид оруулахад,
2. Өгөгдлийг боловсруулахад,
3. Үр дүнгийн тооцоолол хийхэд тус тус гүйцэтгэсэн.

Судалгааны үр дүнгийн зорилттой уялдуулж, мэдээллийн боловсруулалт, дүн шинжилгээнд дараах ангилал, бүлэглэлтийг ашигласан. Үүнд:

А. Ангиллууд:

- Боловсролын түвшний ангилал
- Ажил эрхлэлтийн салбарын ангилал
- Ажил мэргэжлийн ангилал

Б. Бүлэглэлт:

- Оршин суугаа улсаар
- Хүйсээр
- Насны бүлгээр
- Мөнгөн ба мөнгөн бус гуйвуулгын хэмжээ
- Сарын дундаж орлогоор
- Бусад.

1.3 Мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтын өмнө ГХЯ-ны Консулын газар болон дипломат төлөөлөгчийн газрын ажилтнуудад цахим сургалтыг зохион байгуулж, хамтран ажиллах талаар танилцуулсан. Мөн гадаад улсад Монгол Улсын иргэдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын ажилтан, удирдлагуудад судалгааны зорилго, хүрэх үр дүнгийн танилцуулга, чиглэлийг өгч ажилласан.

Зураг 1.1. Судалгааны мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт



Мэдээлэл цуглуулах явцад гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэдийг судалгаанд идэвхтэй оролцуулах зорилгоор богино хэмжээний 2 дүрс бичлэг, 14 зурагт хуудсыг боловсруулж ГХЯ, ДТГ-ын албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээний суваг (Facebook)-т байршуулсан. Мөн үндэсний томоохон телевизүүдээр дамжуулан иргэдэд судалгааны талаар ойлголт, ач холбогдлыг тайлбарлан таниулах ажлыг гүйцэтгэсэн.

Судалгаанд оролцогчид сайн дурын үндсэн дээр өөрсдийн цахим төхөөрөмжийг ашиглан судалгааны асуулгыг нөхөж, ҮСХ-ны холбогдох албан хаагчид мэдээллийн чанар, бүрдэлтэд хяналт тавьж ажилласан.

1.4 Хариултын түвшин

Судалгаанд гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа 18, түүнээс дээш насны нийт 2023 иргэд сайн дураар хамрагдсанаас 158 оролцогчийн мэдээлэл, үүнээс

- давхардсан болон бүрэн бус 13,
- гадаад улсад харьяалалтай 124,
- аль ч улсад харьяалалгүй 21 гэсэн шалтгаанаар хасагдаж, үлдсэн 1865 иргэний мэдээллийг тайланг боловсруулахад ашигласан.

Хүснэгт 1.3. Судалгаанд оролцогчдын нийт тоо, тайлан боловсруулахад боломжтой болон хасагдсан шалтгаанаар

Үзүүлэлт	Тоо	Хувь
Тайлан боловсруулахад боломжтой асуулга бөглөсөн иргэдийн тоо	1865	92.2
Мэдээлэл боловсруулалтаас хасагдсан	158	7.8
Давхардсан, мэдээлэл бүрэн бус	13	0.6
Гадаад улсад харьяалалтай (Өөр улсад)	124	6.1
Харьяалалгүй	21	1.0
Нийт	2023	100.0

Өөр улсын харьяат болсон 124 иргэн Казахстан (49), АНУ (18), Франц (12), Их Британи (11), Ирланд (11), Швед (8), БНСУ (6), Чех (4), Австрали (3), Турк (3), Япон (3) болон бусад улсад амьдарч байна.

2 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ШИНЖ БАЙДАЛ

2.1 Хүн ам зүйн мэдээлэл


Судалгаанд оролцсон тайлан боловсруулах боломжтой гэж үзсэн 1865 иргэдийн бүрдүүлсэн мэдээллийг ашиглан мэдээлэл боловсруулалтыг гүйцэтгэсэн. Цаашид, эдгээр иргэдийг судалгаанд оролцогчид гэж авч үзнэ. Судалгаанд оролцогчдын 37.6 хувь нь эрэгтэйчүүд, 62.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 2.1. Судалгаанд оролцогчдын тоо, хүйсийн харьцаа, насны бүлэг, хүйсээр, хувь

Насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
18-22	177	68	109	62.4
23-30	449	188	261	72.0
31-40	738	278	460	60.4
41-50	371	124	247	50.2
51, түүнээс дээш	130	43	87	49.4
Бүгд	1865	701	1164	60.2

Судалгаанд оролцогчдын насны бүлгийг авч үзэхэд 23-40 насны бүлгийн иргэд хамгийн өндөр хувь (63.6 хувь)-ийг эзэлж байна.


Зураг 2.1. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа, зарим улсуудаар, хувь



Судалгаанд оролцогч 100 эмэгтэй тутам дунджаар 60.2 эрэгтэй ногдож байгаа бөгөөд оршин суугаа улсуудаар харилцан адилгүй байна. Судалгаанд оролцогчдын дундаж хүйсийн харьцаанаас Казахстан, Япон, Австрали, АНУ, Турк, Франц, Чех улсуудынх өндөр дүнтэй байна.

Судалгаанд оролцогчдын 0.6 хувь нь боловсролгүй, 99.4 хувь нь боловсролтой иргэн байгаа бөгөөд үүнээс 43.8 хувь нь бакалаврын болон дипломын дээд, 30.8 хувь нь магистр болон доктор, 17.6 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байна.

Зураг 2.2. Судалгаанд оролцогчдын тоо, боловсролын түвшин, хувиар




Судалгаанд оролцогчдын боловсролын түвшнийг улсуудаар авч үзвэл АНУ, БНСУ, БНХАУ-д магистр, түүнээс дээш, Япон, Австрали, Их Британи, Франц улсуудад дипломын болон бакалаврын боловсролтой иргэд тэргүүлж байна.

Хүснэгт 2.2. Судалгаанд оролцогчдын тоо, боловсролын түвшин, оршин суугаа улс, хувиар

Улс	Бүрэн дунд, түүнээс доогуур	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дипломын болон бакалаврын	Магистр, түүнээс дээш
Чех	40.4	7.4	47.1	5.1
БНХАУ	41.2	4.1	22.4	32.4
ОХУ	41.7	2.1	27.1	29.2
Швед	30.2	12.7	46.0	11.1
Казахстан	25.9	11.6	47.6	15.0
Франц	23.4	11.2	48.6	16.8
Турк	20.0	14.0	44.0	22.0
Швейцар	21.6	7.8	43.1	27.5
ХБНГУ	19.0	6.9	50.0	24.1
Австри	10.0	15.0	45.0	30.0
Япон	9.8	6.7	58.3	25.2
БНСУ	9.8	4.9	38.9	46.5
Их Британи	11.8	1.5	52.9	33.8
АНУ	8.7	3.5	43.0	44.8
Австрали	4.7	5.4	56.8	33.1
Бусад улс	14.2	0.9	45.3	30.8
Бүгд	19.0	6.4	43.8	30.8

Судалгаанд оролцогч магистр, түүнээс дээш боловсролтой иргэдийн 51.6 хувь нь гадаадад боловсрол эзэмшсэн бол дипломын, бакалаврын дээд боловсролтой иргэдийн 52.8 хувь нь Монгол Улсад боловсрол эзэмшсэн байна.

Зураг 2.3. Судалгаанд оролцогчдын тоо, хаана боловсрол эзэмшсэнээр, хувь



Судалгаанд оролцогчдын 75.0 хувь нь мэргэжилтэн болон менежер гэсэн үндсэн мэргэжилтэй байна. Судалгаанд оролцогчдын үндсэн мэргэжлийг хүйсийн хувьд авч үзэхэд эрэгтэй, эмэгтэй ялгаагүй мэргэжилтэн давамгайлж байна.

Хүснэгт 2.3. Судалгаанд оролцогчдын тоо, үндсэн мэргэжил, хүйсээр, ҮАМАТ-оор, хувь

ҮАМАТ	Хүйс				Нийт	
	Эрэгтэй		Эмэгтэй			
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Зөвсэгт хүчний ажил, мэргэжил	2	0.3	-	-	2	0.1
Менежер	60	8.6	87	7.5	147	7.9
Мэргэжилтэн	448	63.9	803	69.0	1251	67.1
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	22	3.1	31	2.7	53	2.8
Контор, үйлчилгээний ажилтан	12	1.7	33	2.8	45	2.4
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	18	2.6	51	4.4	69	3.7
Худалдаа, үйлчилгээний ажилтан	2	0.3	2	0.2	4	0.2
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	54	7.7	37	3.2	91	4.9
Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч	28	4.0	6	0.5	34	1.8
Энгийн ажил, мэргэжил	2	0.3	3	0.3	5	0.3
Мэргэжилгүй	11	1.6	25	2.1	36	1.9
Хариулаагүй	42	6.0	86	7.4	128	6.9
Нийт	704	100.0	1164	100.0	1865	100.0

Судалгаанд оролцогчдын 64.0 хувь нь гэрлэсэн (батлуулсан болон батлуулаагүй), 30.3 хувь нь гэрлээгүй байна. Насны бүлэг нэмэгдэх тусам гэрлээгүй иргэдийн хувийн жин буурах хандлагатай байна.

Хүснэгт 2.4. Судалгаанд оролцогчдын тоо, гэрлэлтийн байдал, насны бүлгээр, хувь

Насны бүлэг	Бүгд	Гэрлээгүй	Гэрлэсэн, батлуулсан	Гэрлэсэн, батлуулаагүй	Салсан/ тусгаарласан	Бэлэвсэн
Бүгд	100.0	30.3	56.6	7.4	4.3	1.4
18-22	100.0	95.5	3.4	0.6	0.0	0.6
23-30	100.0	53.5	33.9	10.9	1.6	0.2
31-40	100.0	16.7	69.1	8.7	5.0	0.5
41-50	100.0	7.3	81.1	5.1	5.1	1.3
51, түүнээс дээш	100.0	4.6	66.2	3.8	13.1	12.3


ОХУ, БНХАУ улсад амьдарч байгаа иргэдийн 54.7-60.4 хувь нь гэрлээгүй, Чех, Швед, Франц, Швейцар, АНУ, Их Британи, БНСУ, Япон, ХБНГУ, Австрали, Австри амьдарч байгаа иргэдийн 50.0-79.4 хувь нь гэрлэлтээ батлуулсан байна.

Хүснэгт 2.5. Судалгаанд оролцогчдын тоо, гэрлэлтийн байдал, улсаар, хувь

Улс	Бүгд	Гэрлээгүй	Гэрлэсэн, батлуулсан	Гэрлэсэн, батлуулаагүй	Салсан/ тусгаарласан	Бэлэвсэн
БНСУ	100.0	28.3	55.4	8.2	7.1	1.1
АНУ	100.0	18.3	70.0	7.0	3.5	1.3
Япон	100.0	40.5	53.4	4.3	0.6	1.2
Казахстан	100.0	40.1	49.0	4.8	4.1	2.0
Чех	100.0	19.1	52.9	22.1	2.9	2.9
Австрали	100.0	13.5	79.1	4.7	2.7	0.0
БНХАУ	100.0	54.7	38.8	3.5	1.8	1.2
ХБНГУ	100.0	37.9	55.2	0.0	3.4	3.4
Швед	100.0	9.5	79.4	4.8	3.2	3.2
Франц	100.0	22.4	55.1	15.9	3.7	2.8
ОХУ	100.0	60.4	31.3	6.3	0.0	2.1
Турк	100.0	30.0	44.0	16.0	10.0	0.0
Австри	100.0	35.0	50.0	10.0	5.0	0.0
Швейцар	100.0	33.3	43.1	2.0	19.6	2.0
Их Британи	100.0	32.4	63.2	0.0	4.4	0.0
Бусад улс	100.0	34.2	60.5	2.6	2.6	0.0


Судалгаанд оролцогчдын 65.8 хувь нь өрхийн 1, түүнээс дээш гишүүнтэй хамт амьдардаг бөгөөд 39.5 хувь нь 1-3 гишүүнтэйгээ, 26.3 хувь нь 4, түүнээс дээш гишүүнтэйгээ амьдарч байна.

Зураг 2.4. Судалгаанд оролцогчдын тоо, хамт амьдарч байгаа гишүүдийн тооны бүлгээр, хувиар



Гэр бүлийн аль нэг гишүүнтэйгээ хамт амьдардаг иргэдийн 79.5 хувь нь эхнэр/нөхөр, 77.7 хувь нь хүү/охины хамт буюу гэр бүлээрээ амьдарч байна.


Зураг 2.5. Судалгаанд оролцогчдын тоо, хамт амьдардаг өрхийн гишүүний хамаарлаар, хувиар (давхардсан тоогоор)



3 ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН


Судалгаанд оролцогчид нь дунджаар 6.6 жил гадаадад амьдарч байгаа бөгөөд тэдгээрийн 7.8 хувь нь 1 жил хүртэл, 46.0 хувь нь 2-5 жил, 22.5 хувь нь 6-10 жил, 10.6 хувь нь 11-15 жил, 13.1 хувь нь 16, түүнээс дээш жил амьдарсан байна.

Зураг 3.1. Судалгаанд оролцогчдын тоо, гадаад улсад амьдарсан хугацаагаар, хувь




Судалгаанд оролцогчдын 98.9 хувь нь Монгол Улсад, 1.1 хувь нь гадаад улсад төржээ. Монгол Улсад төрсөн иргэдийн 46.3 хувь нь Улаанбаатарт, 4.8-7.0 хувь нь Баян-өлгий, Дархан-Уул, Төв аймагт, 3.1-3.4 хувь нь Орхон, Сэлэнгэ, Завхан аймагт, 2.0-2.7 хувь нь Ховд, Хөвсгөл, Өвөрхангай, Дорнод, Дундговь, Архангай, Говь-Алтай, Увс аймагт, 1.0 хүртэл хувь нь бусад аймагт төрсөн байна.

Зураг 3.2. Судалгаанд оролцогчдын тоо, төрсөн аймгаар, хувь



Судалгаанд оролцогчид хамгийн сүүлд 50.2 хувь нь Улаанбаатарт, 6.5 хувь нь Баян-өлгий аймагт, 2.5-4.5 хувь нь Дархан-Уул, Төв, Орхон, Сэлэнгэ, Завхан, Хөвсгөл аймагт, 1.1-2.2 хувь нь Увс, Ховд, Говь-Алтай, Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймагт, 0.4 хувь нь Говьсүмбэр аймагт оршин сууж байсан байна.

Зураг 3.3. Судалгаанд оролцогчдын тоо, Монгол Улсад хамгийн сүүлд амьдарч байсан газар, хувиар



Судалгаанд оролцогчдын 63.9 хувь нь хувиараа ажиллах, суралцах зорилгоор гадаад оронд шилжин иржээ. Эрэгтэйчүүдийн 36.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэх, эмэгтэйчүүдийн 33.5 хувь нь суралцах зорилгоор ирсэн байна. Үндсэн зорилгыг насны бүлгээр авч үзвэл, 18-22 насныхны 85.9 хувь, 23-30 насныхны 47.9 хувь нь суралцах, 31-40 насныхны 36.7 хувь, 41-50 насныхны 33.4 хувь нь хувиараа ажиллах зорилгоор шилжин ирсэн байна.

Хүснэгт 3.1. Судалгаанд оролцогчдын тоо, гадаадад ирсэн үндсэн зорилго, насны бүлэг, хүйсээр, хувь

Үзүүлэлт	Бүгд	Суралцах	Хувиараа ажиллах	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Хөдөлмөрийн гэрээ байгуулах	Албан томилолтоор ажиллах	Бусад
Хүйс							
Эрэгтэй	100.0	30.1	36.8	7.1	1.7	8.3	16.0
Эмэгтэй	100.0	33.5	28.7	17.2	1.3	5.2	14.2
Насны бүлэг							
18-22	100.0	85.9	4.5	4.5	0.0	1.1	4.0
23-30	100.0	47.9	30.1	8.0	1.3	3.1	9.6
31-40	100.0	25.6	36.7	12.7	1.5	6.0	17.5
41-50	100.0	11.6	33.4	24.0	1.6	10.5	18.9
51, түүнээс дээш	100.0	1.5	41.5	17.7	3.1	14.6	21.5
Нийт	100.0	32.2	31.7	13.4	1.4	6.3	14.9


Австрали, ОХУ, БНХАУ руу зорьсон иргэдийн талаас илүү хувь нь суралцах зорилгоор ирсэн бол Чех, Япон, ХБНГУ, Казакстан, Турк, Швед, Франц зэрэг улс руу иргэдийн олонх нь хувиараа ажиллахаар ирсэн байна.

Хүснэгт 3.2. Судалгаанд оролцогчдын тоо, гадаадад ирсэн үндсэн зорилго, улс, хувь

Улс	Бүгд	Сурал-цах	Хувиараа ажиллах	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Хөдөлмөрийн гэрээ байгуулах	Албан томилолтоор ажиллах	Бусад
БНСУ	100.0	36.1	27.2	10.3	2.4	6.3	17.7
АНУ	100.0	26.1	25.7	10.4	0.0	5.2	32.6
Япон	100.0	33.1	47.9	10.4	3.1	3.1	2.5
Казахстан	100.0	23.8	31.3	15.6	0.0	4.1	25.2
Чех	100.0	1.5	90.4	5.1	0.7	0.7	1.5
Австрали	100.0	73.0	10.8	6.1	1.4	4.7	4.1
БНХАУ	100.0	58.2	2.9	17.6	0.0	19.4	1.8
ХБНГУ	100.0	27.6	39.7	19.0	0.0	1.7	12.1
Швед	100.0	0.0	46.0	19.0	12.7	6.3	15.9
Франц	100.0	4.7	35.5	29.9	0.9	1.9	27.1
ОХУ	100.0	54.2	6.3	0.0	0.0	25.0	14.6
Турк	100.0	12.0	40.0	8.0	2.0	10.0	28.0
Австри	100.0	45.0	25.0	20.0	0.0	0.0	10.0
Швейцар	100.0	25.5	29.4	33.3	0.0	3.9	7.8
Их Британи	100.0	27.9	26.5	23.5	0.0	7.4	14.7
Бусад улс	100.0	42.1	36.8	15.8	0.0	0.0	5.3

Судалгаанд оролцогчдын 85.0 хувь нь оршин суух зөвшөөрөлтэй, 15.0 хувь нь оршин суух зөвшөөрөлгүй байна. Турк улсаас судалгаанд оролцогчдын 40.0 хувь нь оршин суух зөвшөөрөлгүй байгаа нь хамгийн өндөр хувь байна. Үүний дараа Швед (22.2 хувь), АНУ (21.3 хувь), БНСУ (22.2 хувь) улсууд удаалж байна.

Зураг 3.4. Судалгаанд оролцогчдын тоо, оршин суух зөвшөөрөлтэй эсэх, улсаар, хувь



Оршин суугаа зөвшөөрлийн хэлбэрийн хувьд 31.5 хувь нь суралцах, 32.9 хувь нь хөдөлмөр эрхлэх, 14.0 хувь нь гэр бүлийн, 6.5 хувь нь албан хэргээр, 4.6 хувь нь цагаачлах, 10.6 хувь нь хувийн бусад зөвшөөрөлтэй байна. Гэр бүлийн зөвшөөрөлтэй оршин суугаа эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс өндөр, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Насны бүлгийн хувьд 18-22 насныхан суралцах, 23-40 насныхан суралцах болон хөдөлмөр эрхлэх, 41, түүнээс дээш насныхан хөдөлмөр эрхлэх болон гэр бүлийн гэсэн зөвшөөрлийн хэлбэрүүд давамгайлж байна.

Хүснэгт 3.3. Судалгаанд оролцогчдын тоо, оршин суугаа зөвшөөрлийн хэлбэр, насны бүлэг, хүйсээр, хувь

Үзүүлэлт	Албан хэрэг	Хөдөлмөр эрхлэх	Гэр бүлийн шалтгаан	Суралцах	Цагаачлах	Хувийн бусад
Хүйс						
Эрэгтэй	8.4	37.7	7.8	29.5	4.9	11.7
Эмэгтэй	5.3	30.0	17.7	32.7	4.4	9.9
Насны бүлэг						
18-22	1.1	5.1	4.5	85.3	1.1	2.8
23-30	3.3	31.4	8.7	48.3	2.2	6.0
31-40	6.1	38.6	12.6	24.1	4.7	13.8
41-50	10.8	34.2	25.3	10.8	7.0	11.9
51, түүнээс дээш	14.6	39.2	20.8	1.5	9.2	14.6
Нийт	6.5	32.9	14.0	31.5	4.6	10.6

Оршин суух зөвшөөрлийн хэлбэрийн хувьд Чех, Швед, Япон улсуудад хөдөлмөр эрхлэх, Австрали, БНХАУ, ОХУ-д суралцах зөвшөөрлийн хэлбэрүүд давамгайлж байна.

Хүснэгт 3.4. Судалгаанд оролцогчдын тоо, оршин суугаа зөвшөөрлийн хэлбэр, улсаар, хувь

Улс	Албан ажил	Хөдөлмөр эрхлэх	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Суралцах	Цагаачлах	Бусад
Чех	0.7	90.4	5.9	1.5	0.0	1.5
БНХАУ	19.4	2.9	17.6	58.2	0.0	1.8
ОХУ	25.0	6.3	0.0	54.2	2.1	12.5
Швед	7.9	57.1	17.5	0.0	4.8	12.7
Казахстан	4.1	31.3	15.6	23.8	6.8	18.4
Франц	1.9	32.7	34.6	4.7	8.4	17.8
Турк	10.0	32.0	10.0	12.0	0.0	36.0
Швейцар	3.9	27.5	35.3	25.5	0.0	7.8
ХБНГУ	1.7	39.7	19.0	27.6	6.9	5.2
Австри	0.0	30.0	20.0	45.0	5.0	0.0
Япон	3.7	52.8	10.4	30.7	0.0	2.5
БНСУ	6.5	29.3	11.1	33.7	1.6	17.7
Их Британи	7.4	26.5	25.0	29.4	4.4	7.4
АНУ	5.2	25.7	10.4	26.1	20.0	12.6
Австрали	4.7	14.2	6.1	72.3	1.4	1.4
Бусад улс	0.0	36.8	15.8	42.1	0.0	5.3

Судалгаанд оролцогчдын 58.9 хувь нь нийтийн орон сууцанд, 16.7 хувь нь бие даасан тохилог сууцанд амьдарч байгаа бол үлдсэн нь хажуу өрөө болон бусад сууцанд амьдарч байна.

Хүснэгт 3.5. Судалгаанд оролцогчдын тоо, улсаар, амьдран суугаа сууцны төрлөөр, хувь

Улс	Бие даасан тохилог сууц	Нийтийн орон сууц	Хажуу өрөө	Нийтийн байр	Бусад	Бүгд
БНСУ	12.5	63.9	1.6	7.3	14.7	100.0
АНУ	34.8	57.4	3.5	1.7	2.6	100.0
Япон	11.0	65.0	0.6	12.9	10.4	100.0
Казахстан	17.7	44.2	10.9	12.9	14.3	100.0
Чех	7.4	68.4	5.9	8.8	9.6	100.0
Австрали	13.5	60.1	20.9	2.7	2.7	100.0
БНХАУ	4.1	51.2	1.8	19.4	23.5	100.0
ХБНГУ	31.0	62.1	0.0	5.2	1.7	100.0
Швед	14.3	66.7	12.7	3.2	3.2	100.0
Франц	23.4	57.0	0.9	7.5	11.2	100.0
ОХУ	2.1	47.9	4.2	27.1	18.8	100.0
Турк	4.0	72.0	10.0	2.0	12.0	100.0
Австри	20.0	70.0	5.0	0.0	5.0	100.0
Швейцар	19.6	66.7	9.8	2.0	2.0	100.0
Их Британи	39.7	30.9	17.6	5.9	5.9	100.0
Бусад улс	21.1	65.8	2.6	2.6	7.9	100.0
Бүгд	16.7	58.9	5.8	8.2	10.4	100.0

Судалгаанд оролцогчдын 69.9 хувь нь тухайн улсад очсоны дараа тодорхой хэмжээний бэрхшээлтэй тулгарсан бөгөөд 55.6 хувь нь 6 хүртэл сарын хугацааг байр сууриа олоход зарцуулсан байна.

Хүснэгт 3.6. Судалгаанд оролцогчдын тоо, бэрхшээл тулгарсан эсэх, байр сууриа олоход зарцуулсан хугацаагаар, хувь

Үзүүлэлт	Тоо	Дүнд эзлэх хувь
Бэрхшээл тулгарсан эсэх		
Тийм	1304	69.9
Үгүй	561	30.1
Байр сууриа олоход зарцуулсан хугацаа		
1-3 сар	464	24.9
4-6 сар	573	30.7
7-12 сар	250	13.4
1-2 жил	386	20.7
3 ба түүнээс дээш жил	192	10.3
Бүгд	1865	100.0


Гадаад улсад очсоны дараа бэрхшээл тулгарсан иргэдийн хувьд 71.7 хувь нь хэлний, 40.6 хувь нь мэдээлэл олж авах арга замаа мэдэхгүй байх, 30.4 хувь нь ажил олдохгүй байх, 23.3 хувь нь ажиллах зөвшөөрөлгүй, 20.1 хувь нь сургалтын төлбөрийн асуудалтай тулгарчээ.

Зураг 3.5. Бэрхшээл тулгарсан судалгаанд оролцогчдын тоо, бэрхшээлийн төрөл, хүйсээр, хувь, давхардсан тоогоор




Судалгаанд оролцогчдын 50.9 хувь нь төрийн үйлчилгээ авахад хүндрэл бэрхшээл, тулгардаггүй, 49.1 хувь нь тулгардаг байна.

Зураг 3.6. Судалгаанд оролцогчдын тоо, төрөөс үйлчилгээ авахад бэрхшээл тулгарсан эсэх, хувиар




Төрийн үйлчилгээ авахад хүндрэлтэй гэж хариулсан иргэдийн хувьд баримт бичиг, төрийн үйлчилгээ авахад хүндрэлтэй (36.6 хувь), үйлчилгээ хангалтгүй (33.9 хувь), цахим үйлчилгээний хүрэлцээ, боломж хязгаарлагдмал (18.3 хувь), мэдээ, мэдээлэл дутмаг хүртээмж муутай (8.8 хувь) гэж хариулсан байна.

Зураг 3.7. Төрийн үйлчилгээ авахад хүндрэлтэй гэж хариулсан судалгаанд оролцогчдын тоо, төрийн үйлчилгээ авахад тулгарч буй асуудлууд, хувиар



Судалгаанд оролцогчдын 26.6 хувь нь гадагшаа явах зардлаа хуримтлалаар, 26.9 хувь нь бусдын хандив, тусламжаар, 23.1 хувь нь орон сууц, бусад зүйлсээ борлуулсан орлогоор, 18.2 хувь нь зээлээр шийдвэрлэсэн байна.

Зураг 3.8. Судалгаанд оролцогчдын тоо, гадагш явах зардлаа шийдвэрлэсэн байдал, хувиар



Гадаад улсад амьдарснаар судалгаанд оролцогчдын 22.5 хувьд нь ямар нэгэн өөрчлөлт гарсан бөгөөд 47.9 хувьд нь зөвхөн эерэг, 29.6 хувьд нь ямар нэгэн өөрчлөлт гараагүй гэсэн хариултыг өгсөн байна. Харин судалгаанд оролцогчид дан сөрөг нөлөө гарсан гэсэн хариултыг өгөөгүй байна.

Хүснэгт 3.7. Судалгаанд оролцогчдын тоо, гадаадад амьдарснаар гарсан өөрчлөлт, дүн, хувиар

Таны амьдралд өөрчлөлт гарсан эсэх	Дүн	Хувь
Эерэг болон сөрөг өөрчлөлт гарсан	419	22.5
Зөвхөн, эерэг өөрчлөлт гарсан	894	47.9
Зөвхөн, сөрөг өөрчлөлт гарсан	-	-
Өөрчлөлт гараагүй	552	29.6
Нийт	1865	100.0

Гадаад улсад оршин суух нь тухайн иргэн, гэр бүлийн хувьд эрүүл, утаагүй орчин байгаа (81.6 хувь), чанартай хүнс хэрэглэдэг болсон (71.7 хувь), орлого, санхүү сайжирсан (67.5 хувь), соёл, боловсрол, ур чадвар дээшилсэн (53.4 хувь), хүүхдүүддээ хөрөнгө оруулалт хийсэн (28.2 хувь), орон сууцны нөхцөл сайжирсан (28.1 хувь) зэрэг эерэг өөрчлөлтийг дурдсан байна.

Зураг 3.9. Судалгаанд оролцогчдын тоо, тэдгээрийн амьдрал гарсан эерэг өөрчлөлт, хувиар, давхардсан тоогоор



Нөгөө талаас гадаад улсад оршин суух нь тухайн иргэн, гэр бүлийн хувьд гэр бүл салсан (3.6 хувь), гэр бүлийн харилцаа муудсан (16.7 хувь), хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлсөн (11.0 хувь), архи, тамхи, гэмт хэрэгт өртөх эрсдэл нэмэгдсэн (63.2 хувь), эрүүл мэндээрээ хохирсон (5.3 хувь), өрөнд орсон (3.3 хувь), орон байргүй болсон (12.9 хувь) зэрэг сөрөг өөрчлөлтийг дурдсан байна.

Зураг 3.10. Судалгаанд оролцогчдын тоо, тэдгээрийн амьдрал гарсан сөрөг өөрчлөлт, хувиар, давхардсан тоогоор



4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ОРЛОГО

4.1 Хөдөлмөр эрхлэлт

Судалгаанд оролцогчдын 72.2 хувь хөдөлмөр эрхэлдэг гэсэн бол үлдсэн 26.8 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын 51.2 хувь нь 1 ажил, 13.9 хувь нь 2-5 ажил, 7.1 хувь нь 5, түүнээс дээш тооны ажил хийдэг байна.

БНХАУ (26.5 хувь), ОХУ (47.9 хувь), Казакстан (49.0 хувь) зэрэг орнуудад оршин суугаа судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн хувийн жин хамгийн бага байгаа бол ХБНГУ (93.1 хувь), Чех (87.5 хувь), Австрали (85.8 хувь), Австри (85.0 хувь) улсууд хамгийн өндөр байна.

Хүснэгт 4.1. Судалгаанд оролцогчдын тоо, хөдөлмөр эрхэлж байгаа эсэх, улс, ажлын тооны ангиллаар, хувь

Улс	Хөдөлмөр эрхэлдэг	Ажлын тооны ангиллаар			Хөдөлмөр эрхэлдэггүй	Бүгд
		1	2-5	5-аас дээш		
БНСУ	76.1	53.5	16.3	6.3	23.9	100.0
АНУ	84.3	60.0	14.3	10.0	15.7	100.0
Япон	83.4	63.2	16.6	3.7	16.6	100.0
Казахстан	49.0	36.1	7.5	5.4	51.0	100.0
Чех	87.5	55.1	12.5	19.9	12.5	100.0
Австрали	85.8	67.6	16.9	1.4	14.2	100.0
БНХАУ	26.5	21.8	1.8	2.9	73.5	100.0
ХБНГУ	93.1	67.2	17.2	8.6	6.9	100.0
Швед	82.5	52.4	20.6	9.5	17.5	100.0
Франц	73.8	50.5	14.0	9.3	26.2	100.0
ОХУ	47.9	33.3	6.3	8.3	52.1	100.0
Турк	70.0	50.0	16.0	4.0	30.0	100.0
Австри	85.0	50.0	25.0	10.0	15.0	100.0
Швейцар	72.5	45.1	21.6	5.9	27.5	100.0
